

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газар (цаашид “Газар” гэх) нь Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нийслэлийн хэмжээнд үйлдвэрлэл, инноваци, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал боловсруулж, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, нийслэлийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын хүрээнд үйлдвэрлэл, инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн, экспортыг дэмжих, импортыг орлох, өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшил болон үйлдвэрийн салбаруудын харилцан уялдаа, хамтын ажиллагааг хангах үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2.Газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

1.3.Газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 4.2-т заасан төрийн албанд баримтлах үндсэн зарчмуудаас гадна төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

1.4.Газар үйл ажиллагааныхаа явц, үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж, тайлагнана.

1.5.Газар зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Төрийн сан банкинд харилцах данстай байна.

Хоёр. Газрын удирдлага, зохион байгуулалтын бүтэц

2.1.Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтооно.

2.2.Газрын даргыг Нийслэлийн Засаг дарга, орлогч даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Газрын дарга тус тус томилж, чөлөөлнө.

2.3.Газар үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд төлөвлөгөөг Нийслэлийн Засаг дарга батална.

2.4.Газрын дарга дэргэдээ байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Зөвлөл байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга батална.

2.5.Газрын дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.5.1.батлагдсан бүтэц, орон тоо болон хуулиар тогтоосон эрх, хэмжээний хүрээнд ажилтнуудыг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах;

2.5.2.холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, ажилтнуудын цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох;

2.5.3.хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, заавар, дүрэм, журам баталж мөрдүүлэх;

2.5.4.орлогч дарга болон хэлтсийн дарга, албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

2.5.5.байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.5.6.Газрын үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд холбогдох саналаа Нийслэлийн Засаг дарга, холбогдох бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.5.7.сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах;

2.5.8.ажилтнуудын нийгмийн асуудлыг хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ авч ажиллах;

2.5.9.Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

2.5.10.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

2.6.Газрын дарга, албан хаагчид Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай Нийслэлийн Засаг даргаар дамжуулан харилцана.

2.7.Газрын дарга хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгавар, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажиллана.

Гурав. Газрын үндсэн чиг үүрэг

3.1.Газар нь нийслэлийн үйлдвэрлэлийн салбарын хэтийн болон дунд хугацааны стратеги, хөгжлийн зураглалыг тодорхойлох талаар санал боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах бөгөөд энэ хүрээнд дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн өнөөгийн болон хэтийн төлөв байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, нийслэлийн эдийн засгийн өсөлтийг хангасан үйлдвэрлэлийн салбарыг дэмжин хөгжүүлэх хэтийн болон дунд хугацааны стратегийг боловсруулан зохих журмын дагуу батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.2.үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, байгаль орчинд ээлтэй, ногоон үйлдвэрлэлийг төлөвшүүлэх, эко үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.1.3.үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, урт хугацаатай, бага хүүтэй, хөнгөлөлттэй зээл, батлан даалт, даатгал, санхүүгийн түрээс /лизинг/ зэрэг санхүүжилтийн механизмын хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;

3.1.4.үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг боловсронгуй болгох, үр өгөөжийг дээшлүүлэх, тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

3.1.5.гадаад, дотоодын зээл, тусламж, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагуудын тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх;

3.1.6.үйлдвэрлэлд олон улсын стандарт нэвтрүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.1.7.үйлдвэрлэл, хоршоо, бичил бизнес, инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.8.жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.9.жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, бичил үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.10.жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон зөвлөх үйлчилгээг өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

3.1.11.байнгын болон түр худалдаа зохион байгуулж, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, бичил үйлдвэрлэл эрхлэгчдийн зах зээлийг өргөжүүлж, борлуулалтыг нэмэгдүүлэх, шинэ суваг нээхэд дэмжлэг үзүүлэх;

3.1.12.шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээллийг харьяа байгууллага, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжээс гаргуулан авах.

3.2.Газар нь инновацийг хөгжүүлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалт, тогтолцоо бий болгох үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд дэвшилтэт технологид суурилсан, өрсөлдөх чадвар бүхий, нэмүү өртөг шингэсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1.үйлдвэрлэлийн салбарт инновацийг хөгжүүлэх талаар бодлого боловсруулж, Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.2.2.төр, шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын тогтвортой, үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, инновацийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах, хувийн хэвшлийн оролцоог дэмжиж, хамтарсан санхүүжилттэй инновацийн төсөл хэрэгжүүлэх;

3.2.3.инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг санхүү, зээлийн уян хатан бодлогоор дэмжиж, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, түүний хүртээмж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулж, өндөр

технологи болон инновацийн бүтээгдэхүүн, ажиллах хүчний нөөц, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход чиглэсэн төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.2.4.үйлдвэрлэл эрхлэгчид болон инновацийн компаниудад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, уг бодлогыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, биелэлтийг зохион байгуулах;

3.2.5.гадаад орон, томоохон хотуудтай шинжлэх ухаан, технологи, инновацийн хамтын ажиллагааг хөгжүүлж, дэвшилтэт технологийг нутагшуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

3.2.6.Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх болон бусад инновацийн уралдаант шалгаруулалтын төслийн сэдэв, чиглэлийг батлах;

3.2.7.үйлдвэрлэл эрхлэгчид болон инновацийн компаниудын бүртгэл, судалгааг хийж, мэдээллийн сан бий болгох, уг санг хөтөлж баяжуулах.

3.3.Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах бөгөөд энэ хүрээнд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1.үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах.

3.3.2.үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журмын төсөл боловсруулж, Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, биелэлтийг зохион байгуулах;

3.3.3.Аж үйлдвэрийн парк /бусад парк/, кластер, тусгай бүсүүдийг байгуулах, хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

3.3.4.үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийг улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлүүлэх саналыг Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх;

3.3.5.байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд аюулгүй технологид суурилсан, өрсөлдөх чадвар бүхий, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах;

3.3.6.үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг кластерийн зохион байгуулалтад орж, хамтран ажиллах, бизнес, зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

3.3.7.гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын санхүүжилтээр үйлдвэрлэл, технологийн парк, кластерийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, санал, санаачилгыг дэмжиж ажиллах;

3.3.8.жижиг, дунд үйлдвэрийг аж үйлдвэрийн нэгдсэн бодлоготой уялдуулах, кластераар хөгжүүлэх, шинжлэх ухаан, төр, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг зохион байгуулах.

3.4.Газар нь төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулж, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1.хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангах талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, биелэлтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

3.4.2.хөрөнгө оруулалт татах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

3.4.3.нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулах концессын төсөл, арга хэмжээний талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх;

3.4.4.гадаад улс болон олон улсын байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх;

3.4.5.хууль тогтоомжид заасан бусад.

3.5.Газар нь нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл эрхлэгчдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсэн тохиолдолд зөрчлийг арилгуулах асуудлыг холбогдох байгууллагуудад шуурхай уламжилж, шийдвэрлүүлнэ.

3.6.Газар нь нийслэлээс үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шуурхай болгох арга хэмжээ авч ажиллах бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуульд заасан хугацаанд шийдвэрлэж ажиллана.

Дөрөв. Хариуцлага

4.1.Энэ дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Тав. Бусад зүйл

5.1.Энэ дүрмийг зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

5.2.Энэ дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

---o0o---